

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ БА БАГШИЙН ЧАНАР.*(асуудлын дүн шинжилгээ)**Л.Ганцэцэг, МУБИС***Abstract**

At the same time, the science of early childhood continues to advance understanding about how to maximize the lifetime consequences of a child's early development. The period of human development from conception to 6 years old (early childhood) starts with how they recognize this period whether it is essential, healthy, happy, and productive adulthood. Across disciplines – neuroscience to economics, psychology to environmental studies- a common conclusion is emerging that early childhood matters and that investment in the early years reaps especially high dividends.

One of the key aspects of teacher quality is to ensure that preschool education is in line with the concept of sustainable development. Although the quality of early childhood education and development is particularly relevant to the development of the teacher, the quality of education and the effectiveness of the teacher and child are the actor, and our day-to-day demonstration of scientific significance.

Түлхүүр үг

Бага насны хөгжил, сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн өмнөх боловсролын чанар, багшийн хөгжил, тогтвортой хөгжил

Удиртгал

Монголчууд хүүхэд насыг хүндлэн дээдэлдэг нандин уламжлал, үнэт зүйлстэй ард түмэн билээ. “Ухаан суух унаган нас” буюу бага насны чухлыг судар номдоо тодруулан, “хүнээр хүн хийх” амьдралын ухааныг тухайн цаг үеийнхээ шинжлэх ухааны ололт дэвшилтэй хослуулан арвин баялаг туршлагыг зуунаас зуун дамжин, баяжуулсаар ирсэн.

Манай ард түмний “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” хэмээн бага насны хөгжлийн чухлыг онцгойлон тэмдэглэсэн нь өнөөгийн шинжлэх ухааны ололт дэвшил, баримт нотолгоотой чиг шулуун нийцэж байна.

Сүүлийн 15 жилийн хугацаанд дэлхийн нийтээр бага насны хүүхдийн хөгжилд онцгойлон анхаарах болж, хүн төрөлхтний өмнө тулгарч буй ядуурал, хүчирхийлэл, нийгэм-эдийн засгийн доройтол зэрэг тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх, урт удаан хугацааны үр ашигтай, ухаалаг хөрөнгө оруулалт бол 6 хүртэлх насны хөгжлийн хөрөнгө оруулалт гэдгийг судалгаанд үндэслэн, баримтаар нотлон дэвшүүлж байна.

АНУ-ын Харвардын их сургуулийн Хүүхдийн хөгжлийн төвөөс 2017 онд танилцуулсан судалгааны үр дүнгээс үзвэл, бага насанд мэдрэлийн эсийн холбоос үүсэх үйл явц маш богино хугацаанд, өндөр хурдтай

үргэлжилдэг төдийгүй энэ нь насан туршид тасралтгүй үргэлжилнэ. Эрт үүссэн мэдрэлийн эсийн холбооснууд нь дараа дараагийнхаа шинэ холбоосыг үүсэхэд нь сул эсвэл бэх бат суурь болдог.

Бага насны хүүхдийг зохион байгуулалттай хөгжүүлэх үйл ажиллагаа, хөтөлбөрт хамруулах нь тэдний тал бүрийн хөгжлийг дэмжээд зогсохгүй, ирээдүйн хувь хүний болон нийгмийн сайн сайхны төлөө хийж буй хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт болно хэмээн өгүүлж байна.

40 жилийн турш хүний амьдралыг даган судалсан (longitudinal) судалгаанаас эш татвал, цэцэрлэг буюу бага насны хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд нь хамрагдаагүй хүүхдүүдтэй харьцуулбал, ерөнхий боловсролын сургуулиа дүүргэх магадлал 20 хувиар илүү; тасралтгүй, амжилттай ажил эрхлэх магадлал нь 14 хувиар илүү; гэмт хэрэгт холбогдох магадлал нь 24 хувиар бага төдийгүй (Хүснэгт 1) цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүд бусад үе тэнгийнхэнтэйгээ харьцуулбал оюун ухааны коэффициент нь 17 хүртэлх оноогоор илүү байдаг байна (Heskman, 2010).

*  gantsetseg@msue.edu.mn

Хүснэгт 1

Бага насанд хөгжлийн хөтөлбөрт хамрагдах нь насан туршийн амжилттай суралцах, чанартай амьдрахад хэрхэн нөлөөлж буй байдлыг харьцуулсан нь

Илрүүлэх үзүүлэлт	Туршилтын бүлэг (%)	Хяналтын бүлэг (%)
Ерөнхий боловсролын сургуулиа амжилттай дүүргэсэн	65	45
Ажил эрхэлж, чанартай амьдарч байгаа	76	62
Хадгаламжийн данстай	76	50
Гэр бүлээсээ салах магадлал	28	52
Гэмт хэрэгт холбогдох магадлал	28	52

Дээрх тоон үзүүлэлтүүд нь бага насны хүүхдийн хөгжлийг зохион байгуулалттай дэмжихийн чухлыг тодруулж, бага насны оюуны хөрөнгө оруулалт нь насан туршийнх гэдгийг баталж байгаа юм.

Монгол улсын тухайд бага насны хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт бол тэднийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах явдал юм. Бид өнөөдрийн 6 хүртэлх насны хүүхэд бүрийг чанартай боловсролын үйлчилгээнд хамруулснаар улс орны ирээдүй хөгжлийн нэг чухал баганыг бэхэлж буй ач тустай үйл хэрэг болох юм.

Хувь хүний суралцах, боловсрол эзэмших жилүүд нь тухайн хүний орлоготой шууд хамааралтай байдгийг эдийн засагчид өгүүлж байна. Тухайлбал хүний суралцсан жил тутам нь орлогыг 10 хувиар нэмэгдүүлдэг, сургуулийн өмнөх боловсрол нь хувь хүний суралцах жилүүдэд багтах төдийгүй, насан туршийн амжилттай суралцах, чанартай амьдрах үндэс болдог байна (Харри Антонио Патринос, 2017).

Сургуулийн өмнөх боловсролын чанар ба багшийн хөгжил-асуудлын дүн шинжилгээ

XXI зуун бол боловсролын зуун. Эдийн засгийн ахиц дэвшил, нийгмийн тогтвортой байдал, бие хүний амьдралын ололт амжилтыг хангах маш чухал хүчин зүйл бол боловсрол гэж дэлхийн хамтын нийгэмлэг үзэж байна. Эндээс үүдэн сургуулийн өмнөх боловсролын багшийг бэлтгэхийн ач холбогдлыг урьд өмнөхөөс илүү өргөн хүрээнд авч үзэх шаардлага бидэнд тулгарч байна.

Сургуулийн өмнөх боловсролын багшийн онцлог нь, бага насны хүүхдийн хөгжлийг боловсролтой нь, бие бялдрын хөгжлийг эрүүл мэндтэй нь, асран хайрлахыг хамгаалан дэмжихтэй нь, нийгэмшүүлэн урамшуулахыг

сэтгэлийн хөдөлгөөнтэй нь хослуулан байж, нэн хянамгай, хариуцлагатайгаар хүүхдийн унаган авьяасыг тордох, жам ёсны хөгжлийг дэмжих олон талын мэдлэг туршлага, ур чадварыг эзэмшин, түгээдэгт оршдог.

Дэлхий даяар бага насны хүүхэдтэй ажиллах багшийн хариуцлага нэмэгдэн өөрчлөгдөж байна, багш амжилттай суралцах, чанартай амьдрах иргэнийг төлөвшүүлэхэд онцгой үүрэг, хариуцлага хүлээх болсон төдийгүй шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжлийн эрин үед нийгмийн хариуцлагаа ойлгож, биелүүлдэг; бүтээлч, *критикал* сэтгэлгээтэй, багаар ажилладаг; дэлхийн иргэн (*global citizenship*)-ийг төлөвшүүлэх ур чадвартай багшийг бэлтгэхэд онцгойлон анхаарч байна.

Нөгөө талаас сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний болон хөгжүүлэх үйл ажиллагааны чанар нь багшийн хөгжлөөс онцгой хамраалтай байдаг хэдий ч багш, хүүхэд аль нь үйлийн эзэн байснаар үйл явц идэвхтэй өрнөж, үр дүн эерэгшдэг гэдгийг шинжлэх ухаан нарийвчлан тодруулж, бидний өдөр тутмын үйл ажиллагаа батлан харуулж байна.

Дэлхийд багшийн стандартыг анхлан боловсруулж, мөрдөж эхэлсэн улс орнуудын жишээ болох, АНУ-ын Багшийн мэргэжлийн стандартаас хоёр чухал санааг энд тодотгон өгүүлж байна. Үүнд: (i) “багш суралцагч нэг бүрийн танин мэдэхүй, хэл яриа, нийгэмшихүй, сэтгэлийн хөдөлгөөн, бие бялдрын хөгжлийг таньж мэдсэн байх төдийгүй тэдний жам ёсны хөгжлийг хэрхэн дэмжих талаар шийдвэр гаргаж чаддаг байх; (ii) Багш аливаа мэдээлэл, шинжлэх ухаан, технологийн дэвшил, шинэ арга зүйг ашиглахдаа болгоомжтой, хууль эрх зүйн хүрээнд ажиллахын зэрэгцээ багшийн ёс зүйг *алдалгүй* мөрдөх” зэрэг юм.

Монгол улсын тухайд багшийг бэлтгэх асуудал нэн шинэ асуудал биш юм. Орчин цагийн багшийг тэр дундаа сургуулийн өмнөх боловсролын багшийг бэлтгэх асуудал тэртээ 1920-иод оноос эхтэй.

XIX зууны сүүл XX зууны эхэн үед Япон, Солонгос зэрэг Азийн улс орнуудад хааны ордны нялх балчир үрсийг хүмүүжүүлэх, хөгжүүлэх зорилготой бага насны хүүхдийн “нийгмийн институт” байгуулж байсан бол Монгол улсад тухайн үеийн Орос орны нөлөө, дэмжлэгээр 1920-иод онд хүүхдийн цэцэрлэг байгуулах тогтоол шийдвэр гарч, анхны цэцэрлэг 1924-30 онуудад Улаанбаатар хотод байгуулсан нь орчин цагийн хүүхдийн цэцэрлэгийн эхлэл болсон.

1924 оноос хэрэгжиж эхэлсэн *Багш нарыг бэлтгэх сургуулийн хичээлийн тухай хөтөлбөрт*

“Багш нарыг бэлтгэх сургууль болбоос ерөнхий ухааны дунд зэргийн боловсролтой, олон төрлийн гэгээрэл боловсролын ажилчдыг бэлтгэх зорилготой болмуй. Үүнд 13 аймаг, хотын олон бага сургуулийн багш нар, хүүхдийн цэцэрлэгийн ажилчид хийгээд бичиг үсгийн багш нарыг тус тус бэлтгэмой” хэмээн зааж өгсөн нь Монгол улсад орчин багшийн багшийг бэлтгэх ажлын эхлэл болжээ.

Монгол улсад анхны цэцэрлэгүүд байгуулагдаж эхэлсэн нь “цэцэрлэгийн багш” хэмээх шинэ мэргэжлийг дагуулж, энэхүү мэргэжилтнийг сурган бэлтгэхэд төрөөс шат дараатай арга хэмжээ авч байсан. Тухайлбал, 1940 оныг хүртэл Оросын мэргэжилтэн, сургагч багш нар сургуулийн өмнөх боловсролын салбарын болон цэцэрлэгүүдийн өдөр тутмын үйл ажиллагааны хөгжилд ихээхэн тусыг үзүүлж байсан бол 1941 оноос 3 сарын, 1951 оноос нэг жилийн хугацаатай курсээр цэцэрлэгийн багш нарыг тус тус бэлтгэж байснаа, Гэгээрлийн сайдын 1962 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 172 тоот тушаалаар “Цэцэрлэгийн багш нарыг

бэлтгэх сургууль” нэртэйгээр бие даасан сургуулийг байгуулсан байна.

Монгол улс 1991 оноос дээд боловсролтой цэцэрлэгийн багшийг бэлтгэж эхэлсэн, 2008 оноос сургуулийн өмнөх боловсролын багшийг их сургуульд бакалаврын сургалтын хөтөлбөрөөр бэлтгэж эхэлсэн.

Судалгаанаас үзвэл, төрийн өмчийн 5 их, дээд сургууль, төрийн бус өмчийн 17 их, дээд сургууль сургуулийн өмнөх боловсролын багшийг бэлтгэж байна. Сургуулийн өмнөх боловсрол мэргэжлээр магистр, докторыг төрийн өмчийн 1 болон төрийн бус өмчийн 1 дээд, 1 их сургууль бэлтгэж байна. Сургуулийн өмнөх боловсролын багшийг бэлтгэж буй төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуулиудын мэргэжлийн ба мэргэшүүлэх хичээлийн тооны харьцаа нь харилцан адилгүй байна. 2016 оны байдлаар төрийн өмчийн сургуульд мэргэжлийн 11, мэргэшүүлэх 27 хичээл орж байсан бол төрийн бус өмчийн 12 их, дээд сургуулийн мэргэжлийн хичээл 8-12, мэргэшүүлэх хичээл 9-20 байжээ. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2

Монгол улсад цэцэрлэгийн багш бэлтгэж буй сургуулиудын сургалтын хөтөлбөрийн дүн шинжилгээ

№	Сургуулийн нэр	Мэргэжлийн хичээл	Мэргэшүүлэх хичээл	Нийт
1	МУБИС-ийн СӨБС	11	27	38
2	Засагт хан дээд сургууль	9	20	29
3	Зохиомж дээд сургууль	9	9	18
4	Газарчин дээд сургууль	8	9	17
5	Орхон дээд сургууль	8	13	21
6	Энх-Орчлон дээд сургууль	11	14	25
7	Отгонтэнгэр дээд сургууль	9	17	26
8	Хангай дээд сургууль	12	20	32
9	Шинэ иргэншил дээд сургууль	8	13	21
10	Улаанбаатар эрдэм дээд сургууль	10	16	26
11	Дархан дээд сургууль	9	9	18
12	Гурван эрдэнэ БДС	8	17	25
13	Сити дээд сургууль	7	11	18

Эх сурвалж: Т.Гэрэлтуяа, Б.Тунгалаг нар, 2016

Монгол улс дэлхийн ихэнх улс орнуудын нэгэн адил сургуулийн өмнөх боловсролын багшийг бакалаврын дипломын сургалтын агуулгаар бэлтгэж байна. Энэхүү сургалтын үргэлжлэх хугацаа 3,5-4 жил байна. Мэргэжлийн нэршил нь сургуулийн өмнөх боловсролын багш, олон нийтээр дадсан нэршил нь цэцэрлэгийн багш юм.

Монгол улсын дээд боловсролын хөгжлийн бодлого нь НҮБ-ын Тогтвортой

хөгжлийн зорилтууд-2030, Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний үзэл баримтлал (2016-2030), Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2012-2014) зэрэг улс орны хөгжлийн тэргүүлэх зорилтуудтай уялдаж мэдлэгт суурилсан нийгмийг байгуулах, эдийн хөгжлийг хурдасгах, хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх, нийгмийн тэгш байдлыг баталгаажуулах зэрэгт тусалж чадах дээд боловсролын үр дүнтэй тогтолцоог бий болгоход чиглэж байна.

Багшийг бэлтгэх тогтолцоо тодорхой байх нь ажлын сайн эхлэл төдийгүй бага насны хүүхдийг боловсролын чанартай үйлчилгээнд хамруулах үндэс суурь гэдгийг салбарын хэмжээнд сайтар ойлгох шаардлагатай он жилүүдэд амьдарч байна.

Бага насны хүүхэдтэй ажиллах багшийн хөгжлийг дэмжих үйл явцыг системийн онолын үүднээс харвал дараах 5 бүрэлдэхүүний хүрээнд тодорхойлж болох юм. Үүнд:

- СӨБ-ын багшийн хөгжлийг дэмжих төрийн бодлого
- СӨБ-ын багшийн бэлтгэх эрх зүйн орчин
- СӨБ-ын багшийг бэлтгэх сургалтын хөтөлбөр
- СӨБ-ын багшийн ажлын үнэлэмж
- Багш мэргэжлээр суралцагч, элсэгчдийг дэмжих бодлого зэрэг болно.

Өнөөгийн цэцэрлэгийн багш хэрхэн ажиллаж байгаа талаар цөөн судалгааны үр дүнгээс харвал,

- Цэцэрлэгийн багш өдөрт 10-12 цаг ажиллаж байна.
- Цэцэрлэгийн нэг багш/бүлэгт ноогдох хүүхдийн тоо хэт олон байна. 2017-2018 хичээлийн жилд, цэцэрлэгийн нийт бүлгийн 34.2 хувь нь ачааллаа 2 дахин хүртэлх хувиар хэтрүүлсэн тооны хүүхэдтэй ажиллаж байна.
- Цэцэрлэгийн бүлгийн багш бүр 25-60 хүртэлх тооны хүүхэдтэй “анги даан” ажиллаж байна.
- Цэцэрлэгийн багш 2-6 насны хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийг дэмжин хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахын зэрэгцээ тэднийг асран хамгаалах, хүүхдийн хөгжлийн асуудлаар эцэг эхэд зөвлөх, залуу эцэг эхчүүдийг зан үйл, харилцааны хувьд төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулан ажиллаж байна.
- Цэцэрлэгийн багш хамгийн багаар тооцоход өдөрт 5-6 төрлийн багц үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.
- Цэцэрлэгийн ихэнх бүлгийн багш нар биеийн тамирын болон дууны хөгжмийн багшийн үүргийг давхар гүйцэтгэж байна.
- Цэцэрлэгийн багш хөгжүүлэх үйл ажиллагааныхаа гарын авлага, хэрэглэгдэхүүнийг өөрөө бэлтгэж байна. Цэцэрлэгийн нэг багш бүлгийнхээ хүүхэд нэг бүрийн хөгжлийн онцлогт нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материалыг өөрийн гараар хийж, бүтээдэг (Цэндсүрэн, 2017).

Гэтэл өнөөдрийн Монгол улсын боловсролын эрх зүйн орчин, боловсролын салбарын менежмент, боловсролын үйлчилгээний үр шимийг хүртэгчид нь энэрч хайрлах сэтгэлтэй, өндөр ёс зүйтэй, сурахуйн болон сургахуйн чин хүсэл арвин туршлагатай, хүүхдээ танин арга ухаанд суралцсан, аливаад тууштай багшийг хүсэн хүлээж байна.

Бидний хийсэн асуудлын дүн шинжилгээ нь сургуулийн өмнөх боловсролын багш мэргэжилтний чанарыг сайжруулахад дараах асуудал тулгамдаж байна хэмээн тодруулж байна. Үүнд:

- Үр дүнд суурилсан СӨБ-ын багшийг бэлтгэх хөгжлийн бодлого, эрх зүйн боловсронгуй орчин үгүйлэгдэж байна. Тухайлбал, СӨБ-ын багшийг хэрхэн чанартай бэлтгэх вэ, СӨБ-ын багшийн хөгжлийг хэн, хэрхэн дэмжих вэ зэрэг чиглэлээр эрх зүйн орчныг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Хүүхэд нэг бүрд тэгш боломж олгосон, тэднийг тэгш хамруулсан, хүртээмжтэй СӨБ-ын үйлчилгээний орчныг хөгжүүлэх тухай салбарын хөгжлийн зорилттой нийцүүлэн багшийг бэлтгэх хууль эрх зүйд дүн шинжилгээ, сайжруулалт хийх нь тулгамдаж байна.
- СӨБ-ын багш мэргэжлээр төгсөгчдийн чанар харилцан адилгүй байна. Тухайлбал, СӨБ-ийн багшийг их, дээд сургуулиуд харилцан адилгүй хөтөлбөрөөр бэлтгэж байна. Суралцагсдын болон төгсөгчдийн чанарыг үнэлэх аргачлал үгүйлэгдэж байна. Түүнчлэн цэцэрлэгийн багшийн багшийг бэлтгэх, багшийн багшид тавигдах шаардлага/стандартыг тодорхой болгох хэрэгцээ байсаар байна.
- СӨБ-ын багшийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг нийгмийн болон бага насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, бага насны монгол хүүхдийн хөгжлийн суурь судалгаа хангалтгүй байгааг СӨБ-ын багшийг бэлтгэх, “хэн, хэнийг хэрхэн хөгжүүлэх вэ?”, “хүүхдийн хөгжлийг ямар арга зүйгээр хэрхэн дэмжих нь илүү зохистой вэ?”, “хүүхдийн хөгжилд хэрхэн дүн шинжилгээ хийх вэ” зэрэг асуултад судалгаанд суурилсан, шинжлэх ухааны үндэслэлтэй хариулт, нотолгоо хэрэгтэй байна.
- СӨБ-ын багшийг бэлтгэж буй их, дээд сургуулиудын “суралцахуйн

ба багшлахуйн” орчин хангалтгүй байна. Тухайлбал, Сургуулийн номын сан, сургалтын материаллаг орчны бүрдэл харилцан адилгүй байна. Орчин үеийн дэвшилтэт арга зүйд суралцах, хэрэглэх орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна. Мөн СӨБ-ын багшийг бэлтгэж буй их, дээд сургуулиудын багшлах дадлагын түшиц цэцэрлэгүүдийн чадавхыг бэхжүүлэх нь нэн тулгамдаж байна.

- СӨБ-ын багш мэргэжлээр суралцахаар элсэгчдийн чанар хангалтгүй хэвээр байна. Тухайлбал, СӨБ-ийн багшийн ур чадвараас бага насны хүүхдийн хөгжлийн дэмжих үйл ажиллагааны чанар хамаардаг бол, СӨБ-ын багш мэргэжлээр элсэгчийн чанараас багшийн чанар хамаардаг болохыг бидний өнөөгийн туршлага харуулж байна. СӨБ-ийн багшийг бэлтгэх асуудлыг багш бэлтгэх сургуулиудын элсэгчдийн чанар, чансаанаас эхлээд сургалтын явц, технологи, сургуулиудын хүний нөөцийн болон санхүүгийн менежменттэй холбон авч үзэх шаардлагатай байна. СӨБ-ын багш мэргэжлээр элсэгчийн чанар нь багш бэлтгэх сургалтын орчин нөхцөл, сургалтын технологийн бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтийг хангах зохистой гарц болох юм.

Дүгнэлт

Багшийн хөгжил нь нэг талаас, багшийн бие бялдар, оюун ухаан, сэтгэлийн нэгдэл буюу тэдний эрүүл мэнд, танин мэдэхүй, ёс зүй, сэтгэлийн төлөвшилд гарч байгаа чанарын эерэг өөрчлөлт, нөгөө талаас багшийн мэргэжлийн шинж чанарын нэгдэл гэдгийг мартах учиргүй. Багшийн хөгжлөөс бага насны хүүхдийн хөгжил, улс орны ирээдүй ихээхэн шалтгаалах учиртай гэдгийг сургуулийн өмнөх боловсролын салбарын бодлогын, хэрэгжилтийн, хяналт үнэлгээний зэрэг бүхий л үе шатанд онцгойлон анхаарч ажиллах нь бидний ойрын жилүүдийн зорилт байх болно.

Багшийн хөгжил нь нас, хүйс, ажилласан жилээс нь хамааран өөр хурдтай, нарийн зохицолтой, орчноо өөрчлөн хувиргах шинжтэй, дотоод, гадаад шалтгаалцалтай явагддаг нарийн бөгөөд нийлмэл үйл явц юм. Иймээс багшийн хөгжлийн асуудалд баримт нотолгоонд суурилан, үр дүнд чиглэн олон хувилбараар зохион байгуулах эрх зүйн орчин, бодлого менежмент

нэн чухал байна.

Эцэст нь сургуулийн өмнөх боловсролын багшийг бэлтгэх үйл явцыг чанаржуулан сайжруулах, шинэ зууны СӨБ-ын багшийг бэлтгэхдээ дараах хүчин зүйлсийг онцгойлон анхаарч ажиллах зүйтэй хэмээн үзэж байна. Үүнд:

- Чанартай элсэгч
- Багш бэлтгэх чанартай сургалт
- Төгсөлтийн дараах эргэх холбоо
- Мэргэших сургалт зэрэг болно.

Ашигласан материал

Гэрэлтуяа, Т., Тунгалаг, Б. (2016). Монгол улсад цэцэрлэгийн багш бэлтгэж буй байдалд хийсэн дүн шинжилгээ. Сургуулийн өмнөх болон болон бага боловсролын асуудал, шийдэл олон улсын хурлын эмхэтгэл. х. 334-341. Улаанбаатар

Дэлхийн банк. (2016). Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол: үйлчилгээний хүртээмж, чанар ба хүүхдийн хөгжлийн үр дүн. Улаанбаатар: Дэлхийн банк

Мөнхжаргал, Д. (2016). Сургуулийн өмнөх болон бага боловсролын залгамж холбоо. *Сургуулийн өмнөх болон болон бага боловсролын асуудал, шийдэл олон улсын хурлын эмхэтгэл.* х.10-13. Улаанбаатар

Нонна, Д. (2014). Монгол улсад сургуулийн өмнөх боловсрол хөгжиж ирсэн нь. Улаанбаатр: Ундраг принт

Цэндсүрэн, Т. (2016). Бага насны хүүхдийн хөгжил ба Ухаалаг хөрөнгө оруулалт. Улаанбаатар

Шагдар, Ш. (2005). Монгол улсын боловсролын түүхийн товчоон. Улаанбаатар: Бемби сан
Pia Rebello Britto., Patrice L. Engle., & Charles M. Super. (2013). *Handbook of Early Childhood Development Research and Its Impact on Global Policy.* USA: Oxford University Press

Shonkoff, J.P., & Phillips, D.A. (2000). *From Neurons to Neighborhoods: the Science of Early Childhood Development.* Washington, DC: National Academy Press. .